

# “СЭЛЭНГЭ АР ХӨВЧ” ХК

2020 оны 03 дугаар сар 16 өдөр

№ 20/2

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн  
хурлыг зарлан хуралдуулах тухай*

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Улаанбаатар хотод “Астра Худалдааны төвийн 2-р давхарт 2020 оны 04 сарын 27-ны өдөр 14 цагт хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доорхи асуудлыг хэлэлцэхээр баталсугай.
  - 2.1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх.
  - 2.2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
  - 2.3. 2020 оны ажлын төлөвлөгөө
  - 2.4. ТУЗ болон ГУ-ын 2020 оны зардлын төсөв батлах
  - 2.5. Ногдол ашиг хувиарлахгүй байх ТУЗ-ийн 20/1 тоот тогтоол
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 04 сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2020 оны 03 сарын 20-ний өдөр, 2020 оны 04 сарын 03 -ны өдрүүдэд хурлын зар түгээх СЗХ-ны журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 01-р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материалын жагсаалтыг 02-р хавсралтаар, санал авах хуудсын загвар, агуулгыг 03-р хавсралтаар, Хурлын зарын загварыг 04-р хавсралтаар баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай “Масдак ҮЦК” ХХК -ийн байранд ажлын өдрүүдэд 09-16 цагийн хооронд танилцаж болохоос гадна өөрийн харилцааг брокер дилерийн компаниар дамжуулан танилцаж болохыг дурьдсугай.
7. Санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2020 оны 04 дугаар сар 26 –ний өдрийн 14 цаг байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулах комиссын даргаар Д.Очирбал, гишүүнээр Д.Дэлгэрсайхан нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Т.Оюунцэцэг, гишүүнээр Г.Дагиймаа нарыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар В. Баттулгыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:  Д.Очирбал/



# СЭЛЭНГЭ АР ХӨВЧ ХК

2020 оны 02 сарын 17 өдөр

№20/01

Сүхбаатар сум

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хувиарлахгүй  
байх тухай

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг үндэслэн 2020 онд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА *Б.А. Д. ОЧИРБАЛ*



# “СЭЛЭНГЭ АР ХӨВЧ” ХК

2020 оны 04 дүгээр сарын 27 өдөр

№20/3

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2019 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн тухай*

“Сэлэнгэ Ар Хөвч” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. “Сэлэнгэ Ар Хөвч” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2020 оны төлөвлөгөө, зорилтыг баталсугай.
3. 2020 оны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: ..... / В. БАТТУЛГА /



# “СЭЛЭНГЭ АР ХӨВЧ” ХК

2020 оны 04 дүгээр сарын 27 өдөр

№ 20/4

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтыг удирдлага болгон “Сэлэнгэ Ар Хөвч” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас олонхийн санал авсан

Ердийн гишүүдээр:

1. Ж.Мөнхбаяр
2. Д.Түмэннасан
3. Д.Очирбал
4. Ж.Мөнхтөр
5. Б.Одончимэг
6. Х.Хашбаатар

Хараат бус гишүүдээр:

1. В.Баттулга
2. Д.Энхсайхан
3. Б.Энхбаяр

нарыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр баталсугай.

2. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг томилон ажлуулах, цалин урамшуулалыг тогтоохыг ТУЗ-ын хурлаар шийдвэрлэхийг даалгасугай.

3. Компанийг үр ашигтай удирдахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: ..... / В. БАТТУЛГА /



# “СЭЛЭНГЭ АР ХӨВЧ” ХК

2020 оны 04 дүгээр сарын 27 өдөр

№20/5

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх  
удирдлагын зардлын төсөв батлах тухай*

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ болон ГУ-ийн 2020 оны үйл ажиллагааны төсвийг *900 000* төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: ..... / В. БАТТУЛГА /

